



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 02 өдөр

Дугаар

21

Мандалговь

Б.Долгоржавыг Нийгмийн даатгалын хэлтсийн
Сайхан-Овоо сумын нийгмийн даатгалын байцаагчийн
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Сайхан-Овоо сумын нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Батаагийн Долгоржав 59.3 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Долгоржавын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны дугаар сарын
...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



**Нийгмийн даатгалын хэлтсийн Сайхан-Овоо сумын нийгмийн
даатгалын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн
Б.Долгоржавын тухай дүгнэлт**

1. Б.Долгоржав нь 1999 онд Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд төрсөн. 23 настай, эмэгтэй
2. Боловсролын байдал: 2016-2019 онд Шинжлэх ухаан техникийн их сургуулийг жижиг дунд үйлдвэрлэлийн менежмент мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Б.Долгоржавын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Нийгмийн даатгалын хэлтсийн Сайхан-Овоо сумын нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ